



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2023
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2024 он



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

***БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭ***

1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ – **91.8% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”** байна.


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хариуцан хэрэгжүүлэх 12 арга хэмжээний 11 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар, 1 арга хэмжээ (4.4.10.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар үүрэг хүлээсэн.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 онтой харьцуулахад хэрэгжилтийн үнэлгээний хувь 10.2 хувиар өссөн байна.



Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

Бодлого, арга хэмжээгээр харуулбал:



д/д	Хэрэгжилт	Бүгд	Бодлого	
			Эдийн засаг	Засаглал
1	Хяналтад авсан зорилтын тоо	5	2	3
2	Хяналтад авсан арга хэмжээний тоо	12	3	9
3	100.0 хувь	6	-	6
4	90.0 хувь	3	1	2
5	Үнэлгээний	2	2	-
6	хувь	-	-	-
7	50.0 хувь	-	-	-
8	30.0 хувь	-	-	-
8	Хугацаа болоогүй	1	-	1
9	Хэрэгжилтийн хувь	91.8 хувь	76.6 хувь	97.5 хувь

2023 оны эхний хагас жилийн байдлаар 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх 11 арга хэмжээг хяналтад авч, явцын хэрэгжилтийг тайлагнахад 73.6 хувьтай байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 12 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилт **“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 91.8 хувьтай байв.**

Үндсэн хэрэгжүүлэх нэгжээр нь харуулбал:

- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс 2 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 84.0 хувь;
- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Захиргаа, удирдлагын хэлтэс, мэдээлэл технологийн алба -1) 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0% хувь;
- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь;
- Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Хэлтэс			
			ТӨУЗХ	ТӨБАХ /МТА, ЗУХ/	ТӨХШХ	ХЭЗХ /ТӨУЗХ/
1	Хяналтад авсан арга хэмжээний тоо	11	5	2	2	2
2	100.0 хувь	6	1	2	2	1
3	90.0 хувь	3	2	-	-	1
4	70.0 хувь	2	2	-	-	-
5	50.0 хувь	-	-	-	-	-
6	30.0 хувь	-	-	-	-	-
7	0.0 хувь	-	-	-	-	-
8	Хэрэгжилтийн хувь	91.8 хувь	84.0 хувь	100.0 хувь	100.0 хувь	95.0 хувь

3.2.7.6 "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна гэсэн арга хэмжээ (2020-2022 он) 2023 оны жилийн эцсийн байдлаар нэмэгдэж системд орсон.

Тайлбар: "Эрдэнэт үйлдвэр" ТӨХК нь Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолоор "Эрдэнэс Монгол" нэгдлийн харьяанд ажиллаж байгаа болно. Манай байгууллагын хувьд холбогдох арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлсэн тул 90 хувиар үнэлгээг хийсэн болно.

3.2.7.6, 3.7.8.1 арга хэмжээ нь цаг хугацаа шаардсан урт хугацаанд бүрэн хэрэгжих (ковидын нөхцөл байдал нөлөөлсөн), бүтээн байгуулалт, томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай, хамтран хэрэгжүүлэгч болон шийдвэр гаргагч байгууллагаас хамаарч 70 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэгдлээ.

Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд **4.1.4.1. Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-mongolia платформд холбоно.** энэ арга хэмжээг ТӨБЗГ-аас санал өгч тусгаагүй, алдаа үүссэн байх тул тус байгууллагаас хэрэгжилтийг тайлагнах боломжгүй тул хяналтаас хасуулах саналыг сар болгоны тайлангаар хүргүүлсэн боловч тайлант хугацаанд хасагдаагүй тул хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй нийт арга хэмжээнээс хасаж тооцсон болно.

/2023 оны жилийн эцсийн дэлгэрэнгүй тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан ipeelgee.gov.mn-д 2023.12.27-ны өдөр оруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-1/2620 дугаар албан бичгээр 4 хавсралт 29 хуудас материалыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн/.

2. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэд байршсан 2023 оны жилийн эцсийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг хяналтад авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Монгол Улсын 4 хуулийн 11 заалт;
- Улсын Их Хурлын 13 тогтоолын 27 заалт;
- Улсын Их Хурлын Байнгын хорооны 8 тогтоолын 15 заалт;
- Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 4 заалт;
- Ерөнхий сайдын 2 захирамжийн 2 заалт;
- Засгийн газрын 51 тогтоолын 62 заалт;
- Засгийн газрын хуралдааны 38 тэмдэглэлийн 62 заалт;
- Засгийн газрын 1 албан даалгаврын 2 заалт **нийт 8 төрлийн 120 шийдвэрийн 185 заалтыг** хяналтад авч, хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2023 оны жилийн эцсийн байдлаар **дундаж үнэлгээ 90.1 хувь** байна.

ХЯНАЛТАД АВСАН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ



2023 оны жилийн эцсийн тайлангийн үр дүнгээр нэг удаагийн шинжтэй, бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон -96, чиг үүргийн хувьд манай байгууллагад хамааралгүй-14 нийт 110 шийдвэрийг цаашид цахим сангаас хасах саналтай тэмдэглэгээг хийж баталгаажуулсан болно.

Засгийн газрын шийдвэрийн явцын хэрэгжилтийг сар болгон тайлагнаж байгаа тул холбогдох шийдвэр гарч үр дүнд хүрсэн болон бүрэн хэрэгжсэн шийдвэрүүдийн хэрэгжилтэд өөрчлөлт ороогүй тайлагнагдсан.

Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” ТӨҮГ-ыг, Засгийн газрын 2023 оны 258 дугаар тогтоолоор, “Цемент шохой” ТӨХК-ийг, Засгийн газрын 2023 оны 429 дүгээр тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд тус тус ажиллуулахаар шийдвэрүүд гарснаас хойш дээрх байгууллагуудтай холбоотой гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтэд тодорхой ахиц гараагүй тул явцын хэрэгжилтээр тайлагнасан бөгөөд цахим системд 19 холбогдох шийдвэр бүрийн доор тэмдэглэгээг хийж баталгаажуулсан.

Хяналтад авсан шийдвэрийн үнэлгээний дэлгэрэнгүй:

Д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл	Шийдвэрийн тоо	Хэрэгжилтийг тооцсон заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн (100%)	Хэрэгжих шатанд (70%)	Үүнээс: Хэрэгжилт хангалтгүй (30%)	Хэрэгжээгүй (0%)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ)	Хэрэгжилтийн явцын дүн (хувиар)
1	Монгол Улсын хууль	4	11	9	-	-	-	2	90.1%
2	УИХ-ын тогтоол	13	27	11	9	1	-	6	83.8%
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	8	15	9	5	-	-	1	89.3%
4	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг	3	4	4	-	-	-	-	100.0%
5	Ерөнхий сайдын захирамж	2	2	2	-	-	-	-	100.0%
6	Засгийн газрын тогтоол	51	62	40	12	-	-	10	93.1%
7	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	38	62	32	22	1	-	7	86.7%
8	Засгийн газрын албан даалгавар	1	2	2	-	-	-	-	100.0%
	Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)	120	185	109	48	2	-	26	90.1%

Хариуцсан хэлтсээр:

Д/д	Хариуцсан хэлтэс	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь, тоо				ХБ буюу хугацаа болоогүй	Хэрэгжилтийн хувь
			100.0%	70.0%	30.0%	0.0%		
1	ЗУХ, МТА	21	8	2	-	-	11	94.0%
2	ТӨУЗХ	117	69	36	1	-	11	89.2%
3	ТӨБАХ	39	25	7	1	-	6	91.5%
4	ХЭЗХ	9	3	6	-	-	-	80.0%
5	Бүх хэлтэс	11	9	1	-	-	1	97.0%

/2023 оны жилийн эцсийн дэлгэрэнгүй тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан inelgee.gov.mn-д 2024.02.15-ны өдөр оруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А-1/297 дугаар албан бичгээр 4 хавсралт 127 хуудас материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн/.

Мэдээллийн хүртээмж

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөлийн хурлаар тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгуудыг хийсэн.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын албан хэрэгцээнд зориулж тайлангийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг байгууллагын дотоод сүлжээ эйбл клоуд цахим системийн олон нийт цэсний байгууллагын үйл ажиллагаа, дотоод хяналтын цэс болон байгууллагын вэйб хуудас www.pcsp.gov.mn-нд тус тус байршуулав.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

***БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН
ҮНЭЛГЭЭ***

1. БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Байгууллагын стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулан боловсруулж, төлөвлөгөөнд тусгагдсан **16 зорилтын дундаж 96.8 хувь, 74 арга хэмжээний дундаж 95.0 хувийн гүйцэтгэлтэй** байв.

Тайлант онд хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлэхэд батлагдсан зохион байгуулалтын 5 нэгж, 3 албатайгаар удирдах албан тушаалтан 6, төрийн захиргааны 35, төрийн үйлчилгээний 9, нийт 50 албан тушаалд ажиллалаа. Албан хаагчдын мэргэжлийн ур чадварын хувьд докторант 1, магистр 26, санхүүгийн улсын ахлах байцаагч 7, санхүүгийн улсын байцаагч 4, мэргэшсэн нягтлан бодогч 5 байна.

2023 онд 1,526,982,800.0 төгрөгийн төсөв батлагдаж, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан 2023 оны 06 дугаар сард төсвийн тодотголоор 1,853,283,900 төгрөг болж нэмэгдсэн. Үйл ажиллагааны орлого 5000,000 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж нийт төсөв 1,858,283,900 сая төгрөгөөс урсгал үйл ажиллагааны зардалд 1,854,174,376.01 төгрөгийг зарцуулж, хэмнэлт 4,109,523.99 төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажил байхгүй болно.

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:




Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газраас, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус тус бусад холбогдох хуулийн төслийн хамт 2022 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангах зохицуулалтыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар захирамжаар байгуулсан дээрх хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэх, Эдийн засгийн Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн болон Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга нар ажиллаж байна.

Ажлын хэсэг хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэн 2023 оны 09-10 дугаар сард 7 хоногт 3-4 удаа хуралдаж, саналаа нэгтгэж байсан боловч хуулийн төслийг хууль санаачлагчаас эргүүлэн татсан. Учир нь хуулийн төсөлд зарчмын зөрүүтэй санал их, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр хуулийн төсөл шинээр өргөн барихаар болж, Ажлын хэсгийг шинээр байгуулагдан төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Ажлын хэсгээс зохион байгуулсан.



Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх асуудлаар Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үзэл баримтлал, тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ зэрэг баримтыг боловсруулан Засгийн газрын 2023 оны 01

дүгээр сарын 18-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 4 дүгээр тэмдэглэлээр дэмжсэн.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн. Ажлын хэсгийн саналаар хууль санаачлагчид буцаасан боловч нэмж хөрөнгө тусгах ажил хийгдэж дуусган дахин өргөн мэдүүлэхэд бэлтгэсэн.



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, төрийн өмчийн төлөөлөгчийг томилох, сонгон шалгаруулах, түүнд тавих шаардлага, хэрэгжүүлэх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилгын хүрээнд:

- Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор **“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”**;
- Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор **“Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”**;
- Засгийн газрын 2023 оны 86 дугаар тогтоолоор **“Төрийн өмчит хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”**-ыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 174 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлал”;

- Төрийн өмчит 53 хуулийн этгээдийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг;
- Төрийн өмчит 13 хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн өмчит 36 хуулийн этгээдүүдийн захиралтай 2022 онд байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх тухай”;
- Төрийн өмчит 22 хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг чөлөөлж, томилох тухай;
- Төрийн өмчит 29 хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг тус тус хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн бол;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын 7, 10 дугаар зүйлд:
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт Г-01”-ийн 5 дугаар зүйлд;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай” тогтоолд;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 4 дахь хэсэгт;

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Худалдах, худалдан авах гэрээний маягт”-д тус тус нэмэлт өөрчлөлтийг;
- Төрийн өмчит болон төсөвт 54 хуулийн этгээдэд төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн хяналт шалгалтын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 54 тогтоолыг албажуулан гаргуулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гарч буй захиргааны баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах, хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 38 удаагийн хурлаас гарсан 889 шийдвэр (тогтоол – 843, тэмдэглэл - 46), байгууллагын даргын А тушаал 105, Б тушаал 66 нийт 171 тушаалын төсөл, байгууллагын хэмжээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай байгуулсан 4 гэрээний төслийг тус тус хянан баталгаажуулсан.

Хууль, шүүхийн байгууллагад үүссэн захиргааны 16, иргэний 25, эрүүгийн 16, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэж байгаа 4 нийт 61 хэрэг маргаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Засгийн газрыг төлөөлөн давхардсан тоогоор 105 удаагийн шүүх хуралд оролцож, 25 хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байна.



Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор цаг үеийн болон шинэчлэн найруулагдсан хуулиудын онцлог зохицуулалтын талаар албан хаагчдад дараах сургалтуудыг зохион байгуулав.

- Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны эрх зүйн баримт бичиг гаргахад анхаарах асуудал;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт;
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн ойлголт;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай ойлголт.

Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр:



Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан уг жилийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх Авлигатай

тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан “Авлигын эсрэг НЭГДБЕ” нөлөөллийн аяны урианд нэгдсэн.

Энэ хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх, албан хаагчдад хууль тогтоомжийг таниулан сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд **“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон”** аяныг удирдамжийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд амжилттай зохион байгуулсан.

Аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гаргаж, бүх хэлтэс, албан хаагчдын оролцоог тэгш хангах, шинэлэг, сонирхолтой арга хэмжээнүүдийг санаачлах, бүтээлч хандлагыг бий болгох боломжийг бүрдүүлэх зорилгоор хэлтэс бүр аяны хугацаанд хуваарийн дагуу нэг 7 хоногийг хариуцан удирдамжид заасны дагуу албан хаагчид болон харьяа байгууллагуудад хандсан нөлөөллийн ажлыг нээлттэйгээр санаачлан зохион байгуулав.

“Бид – ёс зүйг эрхэмлэсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяны үр дүнд хууль сурталчлах, мэдлэг олгох 20 гаруй сургалт, мэдлэг сорьсон, танин мэдэхүйн уралдаант, хөгжөөнт тэмцээн 3, ажил хэргийн танилцуулга мэдээлэл 2, оролцоонд суурилсан мэдлэг олгох даалгаварт дадлага ажил 1, харьяа байгууллагуудад нөлөөллийн арга хэмжээг 8 удаа зохион байгуулж, 90 байгууллагын 642 гаруй албан хаагчийг хамруулсан байна.



Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө, аргазүйн ажил /хамрагдалт/

1804

/Давхардсан тоо/

- ТӨБЗГ-ын албан хаагчид
- ТӨХЭТгээдийн албан хаагчид



1361

Сургалт, соён гэгээрүүлэх ажиллагаа



264

Мэдээлэл, аргазүйн дэмжлэг, зөвлөгөө



179


Хуулийн хугацаа сануулах арга хэмжээ



ТӨБЗГ нь авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу харьяа ТӨХЭТгээдийн мэдүүлгийн бүрдүүлэлтийг хариуцан чиглүүлж, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанд нь хяналт тавин, холбогдох тайлан мэдээг нэгтгэж, АТГ-д тайлагнадаг.

Мэдүүлгийн бүрдүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022 /тайлант жилд+/
Мэдүүлгийн бүрдүүлэлтэд хамрагдсан байгууллага (ТӨБЗГ, түүний харьяа ТӨХЭТгээд)	79	76	50	50	50	50	44
Тухайн жилд ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлсэн мэдүүлгийн тоо	984	1195	701	694	692	787	626
Тухайн жилд хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн мэдүүлгийн тоо	22	66	40	48	18	45	29
Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдлийн тоо	1238	2987	1795	2781	2233	2776	1552
АТГ-т хянуулсан албан тушаалд нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)	629	291	294	230	194	235	297

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бүртгээгдсэн мэдүүлэг, мэдэгдлийн тоо:



Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдүүлэг гаргагчаар



■ албан тушаалд томилогдохдоо ■ ТУЗ-ын гишүүнээр томилогдохдоо

Төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн засаглалын чиглэлээр:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хувьцаа эзэмшигчийн 100 хувийн эрхийг хэрэгжүүлж буй 43 хуулийн этгээдийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан.

39 төрийн өмчит хуулийн этгээдүүдийн орлогын төлөвлөгөө 2024 онд 1.46 их наяд төгрөг, зардал 1.37 их наяд төгрөг, цэвэр ашиг 35.0 тэрбум төгрөг, цалингийн сан 195.7 тэрбум төгрөг байхаар төлөвлөөд байна.

2023 онд нийт 39 төрийн өмчит үйлдвэрийн газар болон компаниудын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахад дээрх 39 хуулийн

этгээдүүдийн орлогын төлөвлөгөө 2024 онд 1.46 их наяд төгрөг, зардал 1.37 их наяд төгрөг, цэвэр ашиг 35.0 тэрбум төгрөг, цалингийн сан 195.7 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдсөн байна.

Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж ажилласан - 45, Эрчим хүчний яам - 27, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар - 12 (Эрдэнэс монгол нэгдэл), Сангийн яам - 7, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам - 1, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам - 3, Зам, тээврийн хөгжлийн яам - 3 нийт 98 толгой (“Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа 23 охин, хараат компани, төслийн нэгж, Эрчим хүчний яамны харьяа 7 охин, хараат компани, харьяа 2 охин, хараат компаниудыг оролцуулаад) компани, үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засаг, үр ашгийн үзүүлэлтийг нэгтгэн товхимол гаргасан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 59,237.2 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 14,552.6 тэрбум төгрөгийн орлого олж, 2,075.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2021 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад орлого 36.7 хувиар буюу 3,903.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 100.4 хувиар буюу 1,040.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байв.

Монгол Улсын Засгийн газраас явуулж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг тууштай хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 98 аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын хэмжээ өмнөх оноос 3.9 их наяд төгрөгөөр өсөж, 14.5 их наяд хүрсэн нь ДНБ-ний 27.5 хувь, төлсөн татварын хэмжээ 3.5 их наяд төгрөгт хүрсэн нь татварын нийт орлогын 22.7 хувь, ажиллагсдын тоо 56.9 мянгад хүрсэн нь нийт ажлын байрны 4.9 хувьтай тэнцэж байна.

ДНБ: 27% Ажиллах хүч: 4.2% Нийт 98 төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд

№	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Хуулийн этгээдийн тоо	Тайлант үеийн цэвэр ашиг	Нийт хөрөнгийн дүн	Эздийн өмчийн дүн	Хөрөнгийн өгөөж %	Эздийн өмчийн өгөөж %
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар /Эрдэнэс монгол нэгдэл/	12	1,234,381.6	34,340,875.8	26,770,022.9	3.59	4.61
2	Сангийн яам	7	212,726.8	8,401,534.8	1,381,668.7	2.53	15.40
3	Эрчим хүчний яам	27	(150,248.1)	4,057,294.6	2,460,666.7	(3.70)	(6.11)
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	1	(10,924.6)	252,186.1	(42,986.4)	(4.33)	(62.00)
5	Зам, тээвэр хөгжлийн яам	3	(42,343.1)	1,911,699.8	1,242,486.4	(2.21)	(3.41)
6	Хүнс, хөдөө аж ахуйн яам	3	991.7	27,058.8	26,815.0	3.67	3.70
7	ТӨБЗГ	45	830,497.4	10,246,528.8	6,121,433.5	8.11	13.57
НИЙТ 2022 он		98	2,075,081.88	59,237,178.61	37,960,106.68	3.50	5.47
НИЙТ 2021 он		105	1,035,136.25	53,481,851.06	35,355,140.02	1.94	2.93



Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хамтран төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 98 аж ахуйн нэгжийг эрэмбэлэн, алдаршуулсан болно.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 98 аж ахуйн нэгжийн тухайн жилийн статистик тоон мэдээлэлд үндэслэн борлуулалтын орлого, төсвийн төлбөр, хөрөнгийн дүн, ажиллагсдын тоогоор эрэмбэлэхэд 2022 оны ТОП-5 төрийн өмчит аж ахуйн нэгжээр:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
2. “Эрдэнэс таван толгой” ХК
3. “Төрийн банк” ХК

4. “МИАТ” ТӨХК

5. “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийг тус тус тодорсон болно.

2022 оны жилийн эцсийн байдлаар зарим үзүүлэлтээр эрэмбэлж үзвэл:

Хуулийн этгээдийн нэр	Нийт орлого	Төсвийн төлбөр	Нийт хөрөнгийн дүн	Нийт ажиллаг-садын тоо
1	2	3	4	5
“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	3,741,009,488.70	1,331,453,772.57	5,873,069,665.00	6850
Эрдэнэс Тавантолгой ХК	3,681,597,925.72	1,033,973,729.08	18,777,490,159.00	4504
"Төрийн банк" ХК	459,587,776.04	49,927,390.21	4,164,641,533.62	3658
"МИАТ" ТӨХК	490,404,253.33	22,730,103.95	504,490,488.20	965
"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК	59,865,834.30	11,015,970.46	184,428,889.39	1335

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ГОЛ МАКРО ҮЗҮҮЛЭЛТЭЭР

ДНБ (их наяд.төг)	52.9
Төрийн өмчит 98 ААН-ийн борлуулалтын орлого (их наяд.төг)	14.5
Төрийн өмчит 98 ААН-ийн орлогын ДНБ-д эзлэх хувь (%)	27.5%
Монгол улсын нийт татварын орлого (их наяд.төг)	15.6
Төрийн өмчит 98 ААН-ийн татварын орлого (их наяд.төг)	3.5
Төрийн өмчит 98 ААН-ийн татварын Монгол улсын нийт татварын дүнд эзлэх хувь (%)	22.7%
Нийт ажилчдын тоо (мян.хүн)	1,158.0
Төрийн өмчит 98 ААН-ийн ажиллагчдын тоо (мян.хүн)	55.9
Төрийн өмчит 98 ААН-ийн ажиллагчдын тоо нийт ажиллагчдын тоонд эзлэх хувь (%)	4.9%

Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар:



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлагаар

хангах хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. 2023 онд нийт 98 компанийн 62 Төлөөлөн удирдах

зөвлөлд нийт 528 гишүүн ажиллаж байгаагаас хараат бус 167 гишүүн байна. Төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй 361 гишүүний 21 нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 103 Эрчим хүчний яам, 29 нь Сангийн яам, 4 нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 3 нь Барилга, хот байгуулалтын яам, 21 нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, 1 нь Байгаль, орчин аялал жуулчлалын яам, 2 нь Хууль зүй, дотоод хэргийн яам, 32 Зам, тээврийн хөгжлийн яам, 89 нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 56 нь бусад яам, агентлаг, орон нутгаас /давхардсан тоогоор/ томилогдон ажиллаж байна.



Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилох нийт 86 асуудлыг газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлж, 27 гишүүнийг чөлөөлж, 59 гишүүнийг томилсон бол 219 асуудлаар 89 удирдамж чиглэл өгч ажилласан байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:



Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас 2023 оны 04 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд **Франц улсын Парис хот**, OECD-ийн төв байранд зохион байгуулсан 40 дэх удаагийн OECD Төрийн өмч, хувьчлалын хуралд оролцсон.



байгууллагуудын төлөөлөл оролцсон өргөн бүрээлдэхүүнтэй өндөр ач холбогдолтой хурал болсон.

Хурлаар Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, төрийн өмчит компаниудын өмчлөлийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, өрсөлдөөнийг дэмжих,


Төрийн өмчит компанийн өмчлөл, засаглал, хувьчлалын асуудлаар үндсэн хэлэлцүүлэг зохион байгуулагдаж **OECD-ийн гишүүн 38 улсаас гадна БНХАУ, Филиппин, Касакстан, Индонези, Хорват, Монгол улс зэрэг улс орнууд болон Европын холбоо, Олон Улсын Валютын сан, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэрэг олон улсын**



хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, төрийн өмчит компаниудын комплайнсын асуудал зэрэг үндсэн асуудлаар хуралд оролцсон улс бүр өөрийн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, туршлага, цаашид хэрэгжүүлэхээр зорьж буй зорилтыг танилцуулсан. Мөн OECD-ээс 2015 онд гаргасан Төрийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалын талаарх зөвлөмжийн хэрэгжилт, түүнтэй уялдуулан гаргасан бусад зөвлөмж, гишүүн болон гишүүн бус орнуудад хийгдсэн техникийн туслалцаа, түүний зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг танилцуулсан.

Мөн тус байгууллагаас OECD - Төрийн өмчит компанийн засаглалын талаарх дараагийн 2024 оны үндсэн зөвлөмжийн төслийг гишүүн болон ажиглагч орнуудад танилцуулан, санал солилцлоо.

 Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-д хийх ажлын айлчлалын хөтөлбөрийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл БНХАУ-ын Төрийн зөвлөлийн дэргэдэх Төрийн өмчийн хяналт, зохицуулах хороотой /SASAC/ харилцан ойлголцлын санамж бичиг зурсан. Гарын үсэг зурах арга хэмжээний ёслол 2023 оны 6 дугаар 28-ны өдөр тус улсын Бээжин хотод зохион байгуулагдав.



Монгол-Хятадын Төрийн өмчит компанийн шинэчлэл, хөгжлийн анхдугаар форум:



2023 оны 9 дүгээр сарын 03-наас 07-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод Монгол-Хятадын Төрийн өмчит компанийн шинэчлэл, хөгжлийн форум уулзалтыг уул уурхай, эрчим

хүч, зам тээвэр, хөдөө аж ахуйн зэрэг дөрвөн салбар хэлэлцүүлэгт ангилан зохион байгуулагдсан. Уг форум уулзалтад Монгол Улсын талаас Төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын газар болон 13 төрийн өмчит компанийн төлөөлөл бүхий нийт 40 төлөөлөгчид, БНХАУ-ын талаас Төрийн зөвлөлийн дэргэдэх Төрийн өмчийн хяналт, зохицуулалтын хороо, ӨМӨЗО дахь Төрийн өмчийн салбар хороо болон улсын шинж чанартай 116, ӨМӨЗО, Шинжаан Уйгарын өөртөө засах орон, Гансу муж, Шанси мужийн 115 орон нутгийн өмчит компанийн төлөөлөгчид тус, тус оролцсон.

16 дахь удаагийн Азийн бүсийн төрийн өмчит компанийн засаглалын хурал:



OECD болон SASAC нар хамтран 2023 оны 12 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулсан 16 дахь удаагийн Азийн бүсийн төрийн өмчит компаниудын засаглалын чуулга, уулзалтад оролцож Азийн бүсийн улс, орнуудын Төрийн өмчит компанийн засаглалын бодлогын талаарх туршлагыг судаллаа. Тус уулзалтын хүрээнд:

1. БНХАУ-ын Төрийн өмчит компанийн засаглалын талаар;
2. Азийн бүсийн улс орнуудын өмчлөлийн туршлага, компанийн засаглалтай холбоотой шинэчлэлийн жишээнүүд;
3. OECD-ийн 2024 оны төрийн өмчит компанийн өмчлөлийн талаарх удирдамжийн төслийн танилцуулга;
4. Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдан зөвлөлийг мэргэшүүлэх, түүний үйл ажиллагааны талаар;
5. Төрийн өмч ба тогтвортой хөгжил хоорондын уялдаа;
6. Төрийн өмчит компанийн ногдол ашгийн бодлого зэрэг сэдвүүдийн хүрээнд улс орнууд хэлэлцүүлэг хийж, өөрийн орны туршлагыг хуваалцлаа.



Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газрын агентлаг-Төрийн өмчит компанийн хамтын

ажиллагааны газрын гүйцэтгэх захирал Кон Вай Ман тэргүүтэй төлөөлөгчдийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл тэргүүтэй холбогдох албан тушаалтнууд 2023 оны 5 дугаар сарын 17-нд хүлээн авч, уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үеэр Компанийн засаглал ба төрийн өмчит үйлдвэрийн газрын чиглэлээр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар тохиролцсон.



Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын хөгжлийн агентлагийн Монгол Улсад суугаа суурин төлөөлөгч Том Крохеныг 2023 оны 11 дугаар сарын 27-ны өдөр хүлээн авч, уулзалтыг зохион

байгуулж, АНУ-ын компанийн засаглалын чиглэлийн эрдэмтэн, эксперт судлаачдыг Монгол Улсад урьж, лекц сургалт оруулах талаар зөвшилцсөн. Мөн тус агентлагийн Мэри Луиз тэргүүтэй ажлын багийг 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдөр болон 5 дугаар

сарын 30-ны өдөр хүлээн авч, уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр Монгол улс дахь эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилгоор төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал солилцов.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн солилцох захидлын дагуу БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол Улсад "Буянт-Ухаа" спортын ордны засвар үйлчилгээний төслийг хэрэгжүүлэхээр болсон.



Тус төслийг хүлээлцэх актад Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Миньжуань нар 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлын танхимд гарын үсэг зурж, ёслолын үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа.

"Буянт-Ухаа" спортын ордны засвар үйлчилгээний төслийн ажил дууссанаар олон улсын болон улсын шинж чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах, иргэд биеийн тамираар хичээллэх боломж бололцоо бий болсон. Мөн нийтийн эрүүл мэндэд хувь нэмэр оруулж, соёл урлагийн үйлчилгээ авахад улам хүртээмжтэй, тав тухтай орчин бий болсноороо ихээхэн үр дүн ач холбогдолтой юм.



Даширамд дурдахад тус арга хэмжээний үеэр дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Монгол Улсад төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй БНХАУ-ын төрийн өмчит компаниудын тухай асуудал;
2. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон БНХАУ-ын Төрийн өмчийн хяналт, зохицуулах хорооны /SASAC/, хоорондын өнөөгийн хамтын ажиллагааны нөхцөл байдлын тухай;

3. Монгол Улсын төрийн өмчийн харилцааны салбарт БНХАУ-ын талаас хэрэгжүүлэх хүний нөөцийн сургалт, хөтөлбөрийн тухай.

Компанийн засаглалын олон улсын туршлага, Төрийн өмчийн баялгийн сан, корпорацийн засаглал, үйл ажиллагааны бүтцийг хөгжиж буй болон манай улсын онцлогт илүү ойрхон улсуудын туршлагыг сонгон нарийвчлан судалж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс “Төрийн банк” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК, “Монгол шуудан” ХК, “Багануур ЗӨБЦТСүлжээ” ТӨХК, “Шивээ овоо” ХК нарын **Компанийн засаглалын кодексийн үнэлгээг гаргахад дээрх комданиудын дундаж үзүүлэлт 74.9%-тай** байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах IPO гаргах талаар:

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийг батлагдсан. Тус үндсэн чиглэлийн хүрээнд Төрийн өмчит 20 авто зам засвар арчлалтын компани, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Үндэсний давхар даатгал” ХХК, “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ зэрэг төрийн өмчит хуулийн этгээдүүдийн нийт хувьцааны 34 хүртэлх хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдахаар заасан.

Төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гарган биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах чиглэлээр томоохон ажлын эхлэл тавигдсан. **Энэ хүрээнд:**



“Төрийн банк” ХК-ийн нийт хувьцааны 5% буюу 34,745,000 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 590 төгрөгөөр тооцон 22.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж 5.71 хувийн хувьцааг 7306 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 67.3 тэрбум төгрөг;



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хувьцааны 34% буюу 119,157,603 ширхэг хувьцааг нэгж хувьцааны үнэ 100 төгрөгөөр тооцон 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тооцсон. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болж 34 хувийн хувьцааг 7414 хувь хүн, аж ахуйн нэгж санал ирүүлж, 57.8 тэрбум төгрөг тус тус татан төвлөрүүлсэн болно.



“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах судалгаа, урьдчилсан бэлтгэл хангагдсан, бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулсан, үнэт цаасны танилцуулгыг эцэслэн боловсруулж байна.



“Үндэсний давхар даатгал” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах судалгаа, урьдчилсан бэлтгэл хангагдсан, бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Зөвлөх үйлчилгээ хийх этгээдийг сонгон шалгаруулсан, үнэт цаасны танилцуулга хийгдэж Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн холбогдох зөвшөөрлийг аваад байна. Анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржээр эхлүүлэхээр;



“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн нэмэлт хувьцаа гаргах судалгаа, урьдчилсан бэлтгэл хангагдсан, бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа ба эхний ээлжид хаалттай хувьцаат компани болгохоор;



“Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны оролцоог ханган компанийн хэлбэрт шилжүүлэн инновацийн төв болгох ажлууд тус тус хийгдэж байна.



Автозамын засвар арчлалтын 20 төрийн өмчит компаниудын 34% хүртэлх хувьцааг олон нийтэд биржээр дамжуулан нээлттэй арилжихдаа тус тусад нь олон нийтэд санал болгох нь төдийлөн амжилтгүй болох эрсдэлтэй учир тус төрийн өмчин компаниудыг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулалтад оруулахаар холбогдох байгууллагуудын саналыг авч Засгийн газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор 20 төрийн өмчит авто замын засвар арчлалтын компаниудыг нийлүүлэн “Автозамын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компани болгохоор шийдвэрлэсэн. Тус тогтоолын хүрээнд ТӨБЗГ-ын зүгээс нэгтгэл компанийн дүрмийг баталж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг холбогдох яамдын төлөөллийг хамруулан байгуулсан. Цаашид нэгтгэлийн хэмжээнд 34% хүртэлх хувьцаат биржээр дамжуулан олон нийтэд арилжихаар ажиллаж байна.


Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах

IPO хийх 26 төрийн өмчит хуулийн этгээдүүд							
Санал болгож буй хувь	5.71%	34%	20%	+30.6%	34%	34%	34%
Холбогдох судалгаа, урьдчилсан бэлтгэл хангах	✓	✓	✓	✓	✓	✓	20 АЗЗА компаниудын нийлүүлэн “Автозамын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК байгуулсан. Цаашид тус нэгтгэл компанийн хүрээнд IPO гаргахаар бэлтгэл хангаж байна. САЛБАРЫН ОНЦЛОГТОЙ БАЙГУУЛЛАГА САЛБАРЫН ОНЦЛОГТОЙ БАЙГУУЛЛАГА БЭЛТГЭЛ ХАНГАХ СТРАТЕГИЙН Х/О ТАТАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ
Бэлтгэл ажлын төлөвлөгөө	✓	✓	✓	✓	✓	✓	
Зөвлөх үйлчилгээ	✓	✓	✓	✓	ТӨХК хэлбэрт шилжүүлэх	ТӨХК хэлбэрт шилжүүлэх	
Үнэт цаасны танилцуулга	✓	✓	✓	✓			
Эрх бүхий этгээдийн бүртгэл	✓	✓	✓	✓	СТРАТЕГИЙН ДЭД БҮТЭЦ	САЛБАРЫН ОНЦЛОГТОЙ БАЙГУУЛЛАГА	
Үнэт цаасыг олон нийтэд сурталчлах	✓	✓	АНХДАГЧ ЗАХ ЭЗЭЛД АРИЛЖИХ БЭЛТГЭЛ АЖЛУУД ХИЙГДЭЖ БАЙНА	АНХДАГЧ ЗАХ ЭЗЭЛД АРИЛЖИХ БЭЛТГЭЛ АЖЛУУД ХИЙГДЭЖ БАЙНА	ЭХНИЙ ЭЭЛЖИНД ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛГОХ	САЛБАРЫН ЯАМНЫ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ХК БОЛГОХ	
Үнэт цаасны арилжааны захиалга хүлээн авах	✓	✓					
Арилжааг зохион байгуулах	✓	✓				ИННОВАЦИЙН ТӨВ БОЛГОХ	
	АМЖИЛТТАЙ БОЛСОН	АМЖИЛТТАЙ БОЛСОН					

Орон сууц хувьчлалын талаар:

Төрийн өмчийн орон сууц хувьчлах ажлыг “Орон сууц хувьчлах тухай” хуулийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Аймаг, нийслэлийн орон сууц хувьчлах товчоог байгуулах шийдвэр гаргаж, Орон сууц хувьчлах товчоодтой холбогдох хууль журмын хүрээнд хамтран ажиллалаа.

ОРОН СУУЦ ХУВЬЧЛАЛ





“Дулааны III цахилгаан станц” ТӨХК 42 айлын орон сууц

“Дулааны III цахилгаан станц” ТӨХК үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Буянт-Ухаа-1” хорооллын 15 айлын орон сууц, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд байрлах “Эрчим” хотхоны 27 айлын, нийт 42 айлын орон сууцыг 40-ийг нь үнэ төлбөргүй, 2-ыг нь үнэ төлбөртэй одоо амьдарч байгаа албан хаагчдад нь хувьчлах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж 2023 оны 13 дугаар тэмдэглэлээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлж, Засгийн газрын 2023 оны 289 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлэн, орон сууц эзэмших гэрчилгээг;



“Дархан дулааны цахилгаан станц” ТӨХК 2 айлын орон сууц

“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Дархан сум, 21 хороолол, Өргөө багт байрлах 9 дүгээр байрны 2 айлын орон сууцыг одоо амьдарч байгаа 2 ажилтанд нь үнэ төлбөргүй хувьчлах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж 12 дугаар тэмдэглэлээр дэмжүүлэн, Засгийн газарт хүргүүлэн Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 288 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй хувьчлах шийдвэр гаргуулан гарсан шийдвэрийн дагуу 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр 31, 32 дугаар бүхий Орон сууц эзэмших эрхийн бичгийг;



“Монголросцветмет” ТӨҮГ 3 айлын орон сууц

“Монголросцветмет” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Нийслэлийн Баянзүрх дүүргийн 16, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 3 айлын орон сууцыг Орон сууц хувьчлах тухай хуулийн 6.3-т заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсний дагуу Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 50 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй хувьчлах шийдвэрийг тус тус гаргуулсан.

Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, зохицуулалтын чиглэлээр:

Тайлант онд давхардсан тоогоор 1559 хуулийн этгээдийн 59405 нэрийн нийт 1975.6 тэрбум төгрөгийн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн асуудлыг судлан шийдвэрлүүлж, төрийн өмчийн эд хөрөнгийн зохицуулалт хийсэн байна.



Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах хүрээнд 2023 онд төрийн өмчит нийт 187 байгууллагын 15289 нэрийн 107,9 тэрбум төгрөгийн хөрөнгө, орон нутгийн өмчит нийт 685 байгууллагын 47479 нэрийн 62,9 тэрбум төгрөгийн хөрөнгө цаашид ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох шийдвэр гаргасан байна.


Хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосноор улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах ач холбогдолтой юм.

Төрийн өмчит 45 байгууллагын 192 нэрийн 34.8 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг судлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэв.

Төрийн өмчийн эзэмшил, ашиглалт түрээсийн талаар:

Төрийн өмчийн байр, талбай, хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх гэрээг нийт 900 иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай байгуулж, 3.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүллээ.

Улсын төсөвт 2020-2023 онд төвлөрүүлсэн **түрээсийн орлого**, иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хийсэн **гэрээний тоо**:



“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал”-ын 4.1-д заасны дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2022 оны үнэлгээ, дүн, дүгнэлтийг нэгтгэж, төрийн өмчит **1026 хуулийн этгээдийн гэрээг дүгнэхээс хамрагдалт 98.5 хувь, гэрээний биелэлтийн улсын дундаж үнэлгээ 93.05 хувьтайгаар** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, баталгаажуулж, гэрээний дүнгийн талаарх дүгнэлт, зөвлөмж, зөрчлийн жагсаалтыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Дуудлагын худалдааны талаар:

Төрийн өмчит 149 хуулийн этгээдийн 120 нэр төрлийн хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаж 872,133,359.87 төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Дуудлага худалдааны орлого төвлөрүүлэлт



Монгол Улс дахь ОХУ-ын маргаантай өмчийн асуудлаар:



Монгол Улс дахь ОХУ-ын маргаантай өмчийн асуудлаарх хоёр талын Ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, үр дүнг Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын ээлжит 24 дүгээр хуралдаанд танилцуулсан.

Монгол Улсад байгаа ОХУ-ын өмчийн маргаантай эд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх 2 дугаар шатны ажлын хүрээнд хамаарах жагсаалтад орсон үл хөдлөх хөрөнгө, газрын жагсаалтыг гарган зөвшилцөж Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн төслийн харилцан тохиролцсон. Соёрхон батлуулах ажиллагааг эхлүүлсэн.

ОХУ-ын талтай хамтран Дорнод, Дархан-Уул, Эрдэнэт хот, Хөвсгөл аймгийн Ханх суманд байгаа ОХУ-ын үл хөдлөх хөрөнгөд үзлэг хийж дүгнэлт гаргав.

Төрийн өмчийн хяналт шалгалтын чиглэлээр:



Төрийн өмчийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг 24, системийн хяналт шалгалтыг 10, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 10, Засгийн газрын шийдвэр болон иргэний гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 4 нийт 48 хуулийн этгээдэд батлагдсан удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн байна.


Хяналт шалгалтыг санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч 4, Улсын байцаагч 1, мэргэжилтэн 3 нийт 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 5 аймгийн 9 төрийн өмчит хуулийн этгээдэд баримтын иж бүрэн хяналт шалгалтыг хийж, томилолтоор ажилласан байна.

2023 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд 2022 онд **төрийн өмчит 32 хуулийн этгээдэд хэрэгжүүлсэн хяналт шалгалтаар 15.20 тэрбум төгрөг, 2023 төрийн өмчит 22 хуулийн этгээдэд хэрэгжүүлсэн хяналт шалгалтаар 876.71 тэрбум**



төгрөгийн зөрчил илрүүлснийг танилцуулан, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний 54 тогтоолыг албажуулан, холбогдох газруудад хүргүүлэв.

2018-2023 онд хийсэн хяналт шалгалт



Төрийн өмчит хуулийн этгээдүүдэд хэрэгжүүлсэн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн дүн, шалтгаан:

	Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ	2023/523	73.14	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлдсэн, худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт, үргүй зардал гаргасан.
	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	2023/524	231.91	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлдсэн, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр эд хөрөнгө данс хооронд шилжүүлсэн, худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин үргүй зардал гаргасан.
	Төрийн орон сууцны корпораци ТӨХХК	2023/525	6,213.89	Худалдан авалтын болон нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрсөн, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин үргүй зардал гаргасан.
	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ	2023/764	404.71	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин дээд байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчиж худалдан авалт хийсэн.
	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	2023/575	658.83	Үргүй зардал, гүйцэтгэх захиралд үндэслэлгүй үр дүнгийн урамшуулал олгосон, худалдан авах ажиллагааны хууль тогтоомж зөрчин төлөвлөгөөгүй болон тендер шалгаруулалтын журам зөрчин худалдан авалт зохион байгуулсан.
	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	2023/769	1,035.43	Төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлсэн, Худалдан авалтын хууль тогтоомж зөрсөн, Түрээсийн орлогоос Улсын төсөвт төвлөрүүлээгүй, 69 нэгж талбар газар бүртгэлгүй
	Дулааны III цахилгаан станц ТӨХК	2023/841	509.46	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж ТУЗ-ийн гишүүдэд урамшуулал олгосон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчиж худалдан авалт хийсэн.
	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ	2023/843	494.9	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлдсэн, Түрээсийн төлбөр улсын төсөвт төвлөрүүлээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчиж худалдан авалт хийсэн.
	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	2023/770	304.76	Төлөвлөгөөнд тусгагдаагүй зөвшөөрөлгүй олж бэлдсэн, Худалдан авалтын хууль тогтоомж зөрсөн, Түрээсийн төлбөр улсын төсөвт төвлөрүүлээгүй.
	Найлахын дулааны станц ТӨХК	2023/526	955.8	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилгот гүвшинд тодотгол хийгээгүйн улмаас зардлууд хэтэрсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчиж худалдан авалт хийсэн.
	Дулаан шарын гол ТӨХК	2023/766	85.87	Төлөвлөгөөнд тусгагдаагүй зардалыг санхүүжүүлсэн, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлдсэн, төсөвт өртгийг давуулан худалдан авалт хийсэн
	Багануурын дулааны станц ТӨХК	2023/765	552.13	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж үр зардал, гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн гишүүдэд урамшуулал олгосон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж худалдан авалт хийсэн.
	Монгол шуудан ХК	2023/767	135.3	Компанийн нэр дээр бүртгэлтэй 11 газар эзэмшил тодорхойгүй, баталгаажилт хийгдээгүй, санхүүгийн тайланд үнэлж тусгаагүй 4 газар тусгаагдаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин худалдан авалт хийсэн. Хандивын хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэхдээ НБББББ-г заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй.

Төрийн нийтийн эрх ашгийг хамгаалах хүрээнд, Прокурорын байгууллагатай хамтран ажилласнаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 13 хуулийн этгээд 2.38 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.

Д/д	Хуулийн этгээд нэрс	Уулзалт, зөвлөгөөны үр дүнд барагдуулсан авлага	Барагдуулсан авлагын дүн /төгрөгөөр/	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад барагдуулсан	Барагдуулсан авлагын дүн /төгрөгөөр/	Эвлэрүүлэн зуучлагчид хандсан тоо	Барагдуулсан авлагын дүн /төгрөгөөр/
1	"Хөдөө ажахуйн бирж" ХХК	1	16,417,935.00	-	-	-	-
2	"Налайх АЗЗА" ТӨХК, "Налайхын дулааны станц" ТӨХК	8	324,082,803.00	3	18,453,049.00	6	12,149,403.00
3	"Геологийн судалгаа шинжилгээний төв" ТӨҮГ	1	889,934,119.00	-	-	-	-
4	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	5	928,900.00	-	-	-	-
5	"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК, "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК	4	573,642.00	19	969,659,171.00	-	-
6	"Замын-Үүдийн дулааны цахилгаан станц" ТӨҮГ	5	1,090,258.00	1	3,676,000.00	-	-
7	"Завхан АЗЗА" ТӨХК	1	117,510,135.00	-	-	-	-
8	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	2	16,634,611.00	-	-	-	-
10	"Цемент шохой" ТӨХК, "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК	1	400,000.00	-	-	-	-
11	"Ховдын дулааны станц" ТӨХК	-	-	2	8,022,400.00	-	-
Дүн		28	1,367,572,403.00	25	999,810,620.00	6	12,149,403.00
Нийт дүн							2,379,632,426.00


2023 оны хяналт шалгалтын үр дүнгээр төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэн, **улсын төсөвт төвлөрүүлээгүй 198.60 сая төгрөгийг** хяналт шалгалтын явцад илрүүлж улсын төсөвт нөхөн төвлөрүүлсэн.

Д/д	Хуулийн этгээд	Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого/сая төгрөг	Тайлбар
1	"Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" ТӨХК	59.05	Улсын төсөвт төвлөрүүлсэн
2	"Баянчандмань АЗЗА" ТӨХК	8.79	Улсын төсөвт төвлөрүүлсэн
3	"Налайх АЗЗА" ТӨХК	19.91	Улсын төсөвт төвлөрүүлсэн
4	"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ	3.40	Улсын төсөвт төвлөрүүлсэн
5	"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК	1.73	Улсын төсөвт төвлөрүүлсэн
6	"Булган АЗЗА" ТӨХК	4.80	Улсын төсөвт төвлөрүүлсэн
7	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	9.69	Улсын төсөвт төвлөрүүлсэн
8	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК	2.80	Улсын төсөвт төвлөрүүлсэн
9	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	4.70	Улсын төсөвт төвлөрүүлсэн
10	"Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨҮГ	38.6	Улсын төсөвт төвлөрүүлсэн
11	Харилцаа холбооны зохицуулах хороо	42.67	Улсын төсөвт төвлөрүүлсэн
12	Эрүүл мэндийн яам	1.4	Улсын төсөвт төвлөрүүлсэн
13	Эрчим хүчний яам	1.06	Улсын төсөвт төвлөрүүлсэн

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар:

<p>ЭХЭГ-ын 2022 оны ХЭГ/2994 дугаар албан бичгийн дагуу ТЭЗБГ-ын даргын 2022 оны А/74 дүгээр тушаалаар хяналт шалгалт гүйцэтгэх</p>  <p>Шалгалтын тайланг ЭХЭГ-т хүргүүлэн, үргүй зардлыг "ЗГАБ" УТҮГ-ын захирлалар 4.38 сая төгрөгийг төлүүлсэн.</p>	<p>ЗГХЭГ-ын 2022 оны 94 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын даргын 2022 оны 01/ТТЗ-ЗБТ дугаар удирдамж</p>  <p>Хяналт шалгалтын тайлан боловруулан дэд ажлын хэсэгт хүргүүлсэн. /"УБГЗ" ХНН-ийн туслан гүйцэтгэгчтэй холбоотой баримт материал/</p>	<p>Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн Эдийн засаг, хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтарсан тушаал</p>  <p>Хяналт шалгалтын ажлын тайланг ажлын төлөвлөгөөний дагуу боловруулан, ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлэн /Компанийн үндсэн хөрөнгөтэй холбоотой/</p>	<p>Сангийн сайдын 2023 оны СХЭВГ/01 дугаар удирдамжийн дагуу "Тавантолгой" ХК-ийн санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт</p>  <p>Хяналт шалгалтын ажлын тайланг ажлын төлөвлөгөөний дагуу боловруулан, ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлэн /Компанийн үндсэн хөрөнгөтэй холбоотой/</p>
--	--	---	---

Төрийн өмчийн эзэмших, ашиглах эрхийн газрын зөрчлийн талаар:




Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлын зохион байгуулалтын чиглэлээр:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т заасан ТӨБЗГ-ын дарга, орон тооны бус гишүүд батлагдсан “ХУРАЛДААНЫ ДЭГ”-ийн дагуу 37 удаагийн ээлжит, 1 удаагийн ээлжит бус хуралдаж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тус байгууллагын хариуцан шийдвэрлэхээр заасан төрийн өмчийн асуудлыг хэлэлцэн хамтын шийдвэр гарган ажиллав.



Хуралдааныг 2021 онтой харьцуулвал:



2023 онд 38 удаа хуралдаж, 843 тогтоол, 46 тэмдэглэл нийт 889 шийдвэрийн төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, менежментийн чиглэлээр 181 шийдвэр, хөрөнгийн хөдөлгөөн зохицуулалтын чиглэлээр 652, хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний чиглэлээр 54 шийдвэр, хууль эрх зүйн чиглэлээр 1 шийдвэр, захиргаа удирдлагын чиглэлээр 1 шийдвэр тус тус гарсан байна.



Хуралдааныг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.



Төрийн өмчийн бүргэл, ашиглалт, хөрөнгийн хөдлөл, зохицуулалтын чиглэлээр нийт 652 шийдвэр гарсан бөгөөд агуулгын дэлгэрэнгүйг дараах хүснэгтээс харж болно:

Төрийн өмчийн хяналт, шалгалтын Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, менежмент, засаглалын чиглэлээр нийт 181 шийдвэр гарсан, агуулгын дэлгэрэнгүйг дараах хүснэгтээр харуулвал:

№	АГУУЛГА	ТОО
1.	Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай	92
2.	Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай	9
3.	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай	109
4.	Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай	152
5.	Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай	56
6.	Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах, залруулга хийх, бүртгэх зөвшөөрөл олгох тухай	193
7.	Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн тухай	14
8.	Тогтоол хүчингүй болгох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай	10
9.	Бусад	17
Нийт		652

№	АГУУЛГА	ТОО
1.	Төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөх	32
2.	Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах, тодотгол хийх тухай	53
3.	2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай	36
4.	Зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай, дүрэмд өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах тухай	12
5.	Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж буй гишүүдийг чөлөөлөх, томилох тухай	26
6.	Хуулийн этгээдийн дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай	2
7.	Хариуцлага тооцох	1
8.	Өмч хувьчлал	2
9.	Ногдол ашгийн тухай	2
10.	Нэмэлт хувьцаа гаргах тухай	3
11.	Журам /аргачлал батлах тухай/	1
12.	Хуулийн этгээдийн бусад асуудал	11
Нийт		181

№	ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС	ТОО
1	Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай	54
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС		
1	Тогтоол хүчингүй болгох тухай	1
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС		
1	Орон нутгийн өмчийн газрын төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг батлах тухай	1

Хүний нөөцийн чиглэлээр:

2023 онд нийт 50 албан хаагчтайгаар ажилласан.

ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛЛААР



Удирдах албан тушаалтан – 6



Төрийн захиргааны албан хаагч – 35



Төрийн үйлчилгээний албан хаагч – 9

41

АЛБАН ТУШААЛЫН АНГИЛЛААР

Тэргүүн түшмэл – 1

Ахлах түшмэл – 5

Дэс түшмэл – 35

ХҮЙСЭЭР



Эрэгтэй – 19



Эмэгтэй – 31



Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтний 1 сул орон тоог нөхөх захиалга өгч бүрдүүлэн ажиллав.

Сургалт:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 онд баталсан 2022-2025 онд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор 2023 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллав.

Байгууллагын дотоод нөөц бололцоо болон холбогдох байгууллагуудтай хамтран 21 төрлийн сургалтыг давхардсан тоогоор нийт 720 албан хаагчийг хамруулж, төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай хангагдлаа.



21 төрлийн сургалт

Биелэлт 100.0 хувь



Төрийн албаны тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 37/33 дугаар тушаалаар “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг баталсан. 2023 онд Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад дараах чиглэлээр нийт 8 албан хаагч хамрагдлаа.

1. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад -1;
2. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад – 1;
3. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад – 2;
4. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад – 2;

5. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдаад байна.

Нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын нийгмийн асуудлыг төсвийн боломжит хэмжээнд шийдвэрлэхийг эрмэлзэж, байгууллагын батлагдсан төсвийн зардлаас 47,444,100 сая төгрөгийг зарцуулсан байна.



Албан хаагчдыг ажлын байранд чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд 11,0 сая төгрөг;



Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, Улсын Их хурлын 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу төрийн захиргааны албан хаагчдын ажилласан жилийн судалгааг үндэслэн 8 албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын Б/9 дүгээр тушаалаар зэрэг дэвийн нэмэгдлийг олгосон;



Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол батлагдаж цалинд өөрчлөлт орсоноор нэмэгдсэн цалингийн шатлалаар цалинг тооцон олгож, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг журмын дагуу үнэлж, үнэлгээний багийн шийдвэрийн дагуу үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 40 хувиар тооцон олгосон;



Байгууллагын батлагдсан төсвийн зардлын ангилалд багтаан нийт албан хаагчдын хоол унааны зардлыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 22,000 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн;



Ар гэрт нь гачигдал тохиолдсон 5 албан хаагчид тус бүр 500,000 төгрөг, 1 өндөр настанд 300,000 төгрөг, нийт 2,800,000 төгрөгийн буцалтгүй тусламж, ар гэрийн гишүүдийн эрүүл мэндийн шалтгаанаар 3 албан хаагчдад цалинтай чөлөө олгосон;



Албан хаагчдын орон сууцны асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2 албан хаагчийг орон сууцанд орох, 2 албан хаагчийг Төрийн банкны орон сууцны ипотекийн 6 хувийн зээлд хамрагдахад нь холбогдох газарт дэмжлэг хүсэн уламжлан шийдвэрлүүсэн бол төвлөрсөн халаалтгүй гэр, хашаа байшинд амьдардаг 1 албан хаагчид түлээ нүүрсний мөнгө 300,000 төгрөгийн тусламж олгосон байна;



Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 сарын үндсэн цалингийн дундаж хэмжээтэй тэнцэх буюу 37,642,000 сая төгрөгийг олгосон;



Байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болсноос хойш болон Төрийн өмчийн хороонд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан нийт ахмадуудын нийгмийн баталгааг хангах, ахмад настны талаар баримтлах бодлого бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг бүхий байгууллагын дэргэдэх Ахмадын зөвлөлийг байгууллагын даргын А/79 дүгээр тушаалаар нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

Байгууллагын санхүү төсвийн чиглэлээр:

2023 онд 1,526,982,800.0 төгрөгийн төсөв батлагдаж, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол




батлагдсантай холбогдуулан 2023 оны 06 дугаар сард төсвийн тодотголоор 1,853,283,900 төгрөг болж нэмэгдсэн. Үйл ажиллагааны орлого 5000,000 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж нийт төсөв 1,858,283,900 сая төгрөгөөс Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажилласнаар 1,854,174,376.01 төгрөгийн гүйцэтгэлтэй, 99.8 хувийн зарцуулалттай хэмнэлт 4,109,523.99 төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 0.2 хувийн хэмнэлттэй ажилласан байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөгөөр 580,100.0 сая төгрөг үүнээс ирээдүйн өв санд 540,000.0 сая төгрөг, ногдол ашиг 40,100.0 сая төгрөг, түрээсийн орлого 1,600.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2023 оны гүйцэтгэлээр төсөвт төвлөрүүлсэн орлого 452,885.2 сая төгрөг үүнээс ногдол ашиг 448,361.2 сая төгрөг, дуудлага худалдааны орлого 872.5 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөний биелэлт **79.2 хувиар** биелсэн байна.

Төлөвлөгөөгөөр 580,100.0 сая төгрөг



Гүйцэтгэлээр 452,885.2 сая төгрөг



Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажил байхгүй болно.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

2023 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нийт 5763 албан бичиг ирснээс 3338 нь хариутай, 2425 нь хариу өгөх шаардлагагүй албан бичиг байв. Хариутай 3338 албан бичгээс 3242 буюу 97.1 хувь нь шийдвэрлэгдсэн, 54 буюу 1.6 хувь нь

хяналтад, 42 буюу 1.3 хувь нь хугацаа хэтэрсэн байна. Шийдвэрлэсэн 3242 албан бичгийн 3146 буюу 97.0 хувь нь хугацаандаа, 96 буюу 3.0 хувь нь хугацаа хоцорч шийдвэрлэгдсэн байв.


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас нийт 2632 албан бичгийг холбогдох байгууллага, хуулийн этгээдэд хүргүүлсэн.

2023 онд Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэлтэс, албаны албан хаагчдаас 2022 оны 971 баримт материалыг хүлээн авч, хадгаламжийн нэгж бүрдүүлэн, данс бүртгэлд тусгаж, байгууллагын архивд баяжилт хийв.

Байгууллага, иргэд, албан хаагчдаас ирүүлсэн хүсэлтийн дагуу архивын хадгаламжийн нэгжээс 179 лавлагаа үйлчилгээг үзүүлсэн бол бүртгэлээр 15 баримтыг ашиглалтад олгож, 868 хуудас бүхий 164 баримтад “Хуулбар үнэн” тухай тэмдэглэгээ хийж баталгаажуулсан байна.

Өргөдөл, гомдлын талаар:

2023 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэд, хуулийн этгээд, албан хаагчдаас тус байгууллагад нийт 194 өргөдөл, гомдлыг ирүүлсэн бөгөөд тэдгээрээс 180 буюу 94.7 хувь нь шийдвэрлэгдсэн, 10 буюу 5.2 хувь нь шийдвэрлэх хуулийн хугацаа хоцорсон, 4 буюу 2.1 хувь нь хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхээр холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна. Хугацаа хоцорсон 10 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн бөгөөд эйбл клоүд цахим санд хаагаагүй учраас хугацаа хэтэрсэн төлөвтэй байв.



Мэдээлэл технологийн чиглэлээр:



Байгууллагын <https://pcsp.gov.mn> мэдээллийн сайт, фэйсбүүк пэйж хуудсанд өдөр тутмын үйл явдалтай холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр нийтэлж, сурталчилан, ил тод байдлыг ханган ажилласан. Байгууллагын хэмжээнд эйбл клоүд дотоод цахим сүлжээг ашиглаж, шинээр томилогдсон 4 албан хаагчдад хэрэглэгчийн эрх үүсгэж, ажлаас чөлөөлөгдсөн 4 хэрэглэгчийн эрхийг хассан.



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ



Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индексийг Хараат бус IRIM судалгааны хүрээлэнгээс 12 дахь жилдээ хийсэн байна.

Төрийн байгууллагын цахим ил тод байдлыг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийт үр дүнг улсын хэмжээнд тооцоолсноор цаашид Засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх хөшүүрэг болох зорилготой. Индексийн гол зорилтууд нь Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх, үр дүнг өмнөх жилтэй харьцуулах, цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах юм.

2022 онд улсын түвшинд цахим ил тод байдлын ерөнхий үр дүн улсын хэмжээнд **63.1 хувь** гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал “сул” түвшинд үнэлэгдэж байсан бол 2023 онд **төрийн болон орон нутгийн захиргааны 6 төрлийн 97** төрийн байгууллагын албан ёсны цахим хуудаст 3 гол бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 10 дэд бүрэлдэхүүн, 35 шалгуур үзүүлэлт, түүнийг тодорхойлох 150 асуулт/үзүүлэлтийг ашиглан цахим ил тод байдлын индексийг хэмжихэд




төрийн байгууллагын цахим ил тод байдлын ерөнхий индекс улсын хэмжээнд 65.2 хувь гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индексийг хэмжиж эхэлснээс хойш анх удаа “хангалттай” түвшинд үнэлэгджээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь 2023 онд 97 байгууллагын цахим ил тод байдлын нээлттэй байдлын үнэлгээгээр **68.3 хувиар XXIY байрт, агентлагуудаас XII байрт** тус тус эрэмбэлэгдэж, “хангалттай” түвшинд дүгнэгдсэн байна. (2022 онд 93 байгууллагаас **65.9 хувиар XX байрт, агентлагуудаас VIII байрт**)



Тооцох аргачлал



Индексийн түвшин

Төрөөс мэдээллийг ил тод болгох үйл явц нь зөвхөн төрийн үйл ажиллагааны үр дүнд бус **мэдээллийг ил тод болгох орчин бий эсэх**, түүнийг хэрэгжүүлэх төрийн

байгууллагын чадамж байгаа эсэх, үүний үр дүнд **иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн хялбар, хүртээмжтэйгээр хүрч буй эсэх** үйл явцыг цогцоор үнэлэх юм.

Индексийн үзүүлэлтийг байгууллага бүр өөрийн давуу болон сул талыг танин мэдэхийн тулд харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлана. Энэхүү индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглах юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлаж, авлигатай тэмцэх Шүгэл ажиллагаа, Шүүр ажиллагаа, Шувуу ажиллагаа, Шилжүүлэн авах ажиллагаа, Шил ажиллагаа гэсэн таван үйл ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хүнд суртлыг арилгах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох зорилгоор төрийн өмчит компаниудыг олон нийтийн хяналттай, нээлттэй компани болгох, ур чадвар бүхий менежментийн багийг ажиллуулах, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгох зэрэг үйл ажиллагаануудыг эрчимжүүлсэн.

Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас “Шилэн” ажиллагааг хариуцан хэрэгжүүлж, <https://shilen.gov.mn/board> цахим сайтад төрийн өмчит хуулийн этгээдүүдэд төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийн мэдээллийн судалгааг гаргаж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Цахим ил тод байдлыг бодлогын буюу эрх зүйн орчин, байгууллагын чадамж, нээлттэй мэдээлэл гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд чиглэгдэн хийгдсэн байна.



Байгууллагын төрлөөр үр дүнг өмнөх жилтэй харьцуулсан харьцуулалт:

#	Байгууллагын төрөл	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	2023 оны индекс	2022 оны индекс	Өөрчлөлт
1	Монгол Улсын Яамд	78.9%	74.8%	58.3%	70.7%	66.6%	+4.1%
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	79.7%	75.4%	45.0%	66.8%	62.5%	+4.3%
3	Тохируулагч агентлагууд	79.0%	62.8%	47.4%	63.1%	61.2%	+2.9%
4	Аймгуудын ЗДТГ	78.9%	75.4%	43.5%	66.1%	61.4%	+4.7%
5	Дүүргүүдийн ЗДТГ	78.2%	70.2%	44.5%	63.8%	62.7%	+1.1%
6	Парламентын харьяа байгууллагууд	79.8%	68.5%	48.8%	65.7%	64.5%	+1.2%
	Ерөнхий дундаж	78.8%	66.2%	44.2%	65.2%	63.1%	+2.1%

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал:

Судалгаанд хамрагдсан 30 хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлын дундаж 66.8 (2022 онд 62.5 хувь) буюу өнгөрсөн онтой харьцуулахад 4.3 хувиар өссөн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим ил тод байдлын хувьд 2019 онд 0.624, 2020 онд 45.6 хувь, 2022 онд 65.9 хувь, **2023 онд 68.3 буюу “хангалттай”** түвшинд гэж үнэлсэн байна.

Сайн | >80 Хангалттай | 65-79 Сул | 50-64 Хангалтгүй | 35-49 Муу | <35

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	80.5%	84.5%	96%	61%
2	Татварын ерөнхий газар	74.3%	78%	86%	59%
3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	73.2%	78.5%	83%	58%
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	72.7%	84%	77%	57%
5	Усны газар	72.3%	78%	94%	45%
6	Биеийн тамир, спортын улсын хороо	70.8%	83.5%	89%	40%
7	Цаг уур, орчны шинжилгээний газар	70%	78%	91%	41%
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	70%	78%	84%	48%
9	Биеийн тамир, спортын газар	70%	78%	90%	42%
10	Ойн газар	69.7%	84%	82%	43%
11	Шүүх шинжилгээний ерөнхий газар	68.7%	78%	80%	48%
12	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	68.3%	78%	91%	36%
13	Боловсролын ерөнхий газар	67.7%	79%	85%	39%
14	Үндэсний геологийн алба	67.2%	82.5%	78%	41%
15	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	66.7%	80%	74%	46%
16	Ашигт малтмал, газрын тосны газар	65.8%	83.5%	74%	40%
17	Төрийн худалдан авах ажиллагааны газар	65.2%	82.5%	71%	42%
18	Нийгмийн даатгалын ерөнхий газар	64.3%	78%	73%	42%
19	Мал эмнэлгийн ерөнхий газар	64.3%	78%	73%	42%
20	Жижиг, дунд үйлдвэрийн газар	64%	78%	70%	44%
21	Иргэний нисэхийн ерөнхий газар	63.2%	83.5%	64%	42%
22	Улсын бүртгэлийн ерөнхий газар	63%	78%	66%	45%
23	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	62.7%	78%	69%	41%
24	Оюуны өмчийн газар	62.3%	78%	65%	44%
25	Архивын ерөнхий газар	62.3%	84%	59%	44%
26	Гадаадын иргэн, харьяатын газар	62.3%	78%	65%	44%
27	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	62%	78%	61%	47%
28	Соёл, урлагийн газар	61.3%	78%	63%	43%
29	Гаалийн ерөнхий газар	59%	78%	61%	38%
30	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	58.7%	78%	50%	48%
Хэрэгжүүлэгч агентлагийн индекс		66.8%	79.7%	75.4%	45%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Нийт үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагууд – 2023 он

Сайн >80 Хангалттай 65-79 Сул 50-64 Хангалтгүй 35-49 Муу <35				
Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2023 оны индекс	Өөрчлөлт
1	Зам, тээврийн хөгжлийн яам	64.1%	81.0%	16.9%
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	72.6%	80.5%	7.9%
3	Өвөрхангай аймаг	74.6%	77.5%	2.9%
4	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	74.7%	77.0%	2.3%
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	65.9%	76.3%	10.4%
6	Сангийн яам	75.3%	75.7%	0.4%
7	Монгол банк	70.7%	74.5%	3.8%
8	Татварын ерөнхий газар	70.1%	74.3%	4.2%
8	Орхон аймаг	61.5%	74.3%	12.8%
9	Налайх дүүрэг	60.3%	73.3%	13.0%
10	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	70.1%	73.2%	3.1%
11	Барилга, хот байгуулалтын яам	76.8%	73.1%	-3.7%
11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.1%	73.1%	7.0%
12	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	71%	73.0%	2.0%
13	Гадаад харилцааны яам	69.5%	72.7%	3.2%
13	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	67%	72.7%	5.7%
14	Усны газар	65.8%	72.3%	6.5%
15	Цагдаагийн ерөнхий газар	65.6%	72.2%	6.6%
16	Баянзүрх дүүрэг	63.7%	71.3%	7.6%
17	Завхан аймаг	58%	71.0%	13.0%
18	Биеийн тамир, спортын улсын хороо	56.7%	70.8%	14.1%
19	Увс аймаг	64.4%	70.7%	6.3%
20	Санхүүгийн зохицуулах хороо	66.7%	70.5%	3.8%
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	61.1%	70.0%	8.9%
21	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	57.9%	70.0%	12.1%
21	*Биеийн тамир, спортын газар		70.0%	70.0%
22	*Ойн газар		69.7%	69.7%
22	Архангай аймаг	57.2%	69.7%	12.5%
22	Дундговь аймаг	58.2%	69.7%	11.5%
22	Сэлэнгэ аймаг	57%	69.7%	12.7%
23	Эрүүл мэндийн яам	62%	69.3%	7.3%
23	Улаанбаатар хотын захирагчийн алба	63.4%	69.3%	5.9%
23	Хан-Уул дүүрэг	66.8%	69.3%	2.5%
24	Боловсрол шинжлэх ухааны яам	59.3%	68.7%	9.4%
24	*Шүүх шинжилгээний ерөнхий газар		68.7%	68.7%
24	Хэнтий аймаг	59.6%	68.7%	9.1%
25	Үндэсний статистикийн хороо	63.1%	68.5%	5.4%
26	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	65.9%	68.3%	2.4%
26	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	64.3%	68.3%	4.0%
27	Боловсролын ерөнхий газар	59.5%	67.7%	8.2%
28	Булган аймаг	63%	67.3%	4.3%
29	Үндэсний геологийн алба	61.9%	67.2%	5.3%
30	Соёлын яам	63.1%	67.0%	3.9%
30	Баянхонгор аймаг	63.9%	67.0%	3.1%


Судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг судалгааны баг хүргүүлсэн байна.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллага дотооддоо нийтийн мэдээллийг ил тод байдлыг хангах журам, тушаалыг батлан гаргах, агуулгад мэдээллийн хүрээг нарийвчлан тодорхойлох;

- Цахим хуудаснаас хэрэглэгчид хэрэгтэй мэдээллээ хялбар хайж олох, шууд харилцах, санал гомдол хүлээн авах болон үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх;
- Мэдээллийг цахим хэлбэрээр байршуулахдаа ямар нэг холбогдох хууль тогтоомжийг хангах үүднээс байршуулж байгаа ба хэрэглэгчийн өнцгөөс тэдэнд мэдээлэл хайх, хүлээн авахад хялбар байх талаас нь бодолцон сайжруулах шаардлагатай.

2023 оны төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс болон дэлгэрэнгүй тайланг Хараат бус судалгааны хүрээлэнгийн (IRIM) гүйцэтгэсэн тайлангаас үндэслэл болгон авсан болно. Эх сурвалж: <http://irim.mn/web-monitoring>

2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны жилийн эцсийн байдлаар <https://shilendans.gov.mn/organization/8424?ry=2023> шилэн дансны цахим системд төсөв/гүйцэтгэлийн **16 төрлийн мэдээлэл 76, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 4 төрлийн мэдээлэл 27, бусад 7 төрлийн мэдээлэл 73 нийт 27 төрлийн 176** мэдээллийг хугацаанд нь оруулж байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн байдал, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заасны дагуу мэдээллээ бүрэн илгээсэн байдал 2023 онд хуулийн хугацаанд цахим системд оруулсан боловч мэдээлэл оруулах хуулийн хугацаа өнгөрснөөс хойш 2 мэдээлэлд нэмэлт оруулснаар хэрэгжилт **98.9 хувьтай** байна.

Эх сурвалж: <https://shilendans.gov.mn/organization/8424?ry=2023>

3. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ



Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасан “авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасан “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийн хүрээнд 62 нэгж үзүүлэлтүүдийг хамруулан 7 дахь удаагийн буюу 2023 оны “Шударга байдлын үнэлгээ”-ний судалгаагаар судалгаанд хамрагдсан 71 байгууллагаас **82.1 оноогоорбайрт**, 33 агентлагуудаас**байрт** эрэмбэлэгдэж, **улсын (.....оноо) болон агентлагийн (.....оноо)** дунджаас дээгүүр байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны шударга байдлын үнэлгээ **76.5 оноогоор эрэмбэлэгдэж**, 78 байгууллагаас **XXIV байрт**, 31 агентлагуудаас **XIII байрт** үнэлэгдэж байсан бол 2023 онд 5.6 оноогоор үнэлгээ өссөн сайн үзүүлэлттэй байна.

Шударга байдлын түвшний үнэлгээг гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ гэсэн ерөнхий 3 бүлгийн хүрээнд мэдээлэл цуглуулж үнэлгээг гаргасан байна.

Шударга байдлын үнэлгээ -2023 он



Сүүлийн 4 жилээр харьцуулбал



ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ГАНБОЛД

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
(2023 он)**

2024.03.01

Улаанбаатар хот

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	90.1%	0.6	54.6
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.8%		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	95.0%	0.2	19.5
	2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100.0%		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	68.3%	0.2	16.6
	2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.9%		
	3.Шударга байдлын түвшний үнэлгээ	82.1%		
Ерөнхий үнэлгээ:		89.6%	1.0	90.7

-----o O o-----